

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол

гаргах тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 128/ШШ2025/0534 шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2025 оны 10 дүгээр сарын 01-ний 221/МА2025/0631 дүгээр магадлалыг эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлд заасан үндэслэлээр хариуцагч Нийслэлийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/646 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 04 дүгээр хорооны нутаг дэвсгэрт төвлөрсөн авто автомашины зогсоол, үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар 2830 м.кв эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.3.1 дэх заалт, 35.3.5 дахь хэсгийг зөрчиж байсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтогдсон тул Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/646 дугаар захирамжийн хавсралтын 15 дахь хэсгийг хүчингүй болгосон.

Барилга хот байгуулалтын яамны Хяналт шалгалтын газраас 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр иргэн Г.Баттүшигийн барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын загвар зурагт хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулсан бөгөөд тус шалгалтаар Кадастрын зураглал ба газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт заасныг зөрчсөн болохыг тогтоосон үйл баримтыг харгалзан үзэлгүйгээр шийдвэрлэсэн.

Хотын стандарт Хяналтын газраас 2023 оны 12 дугаар сарын 21-ний 01/1667 дугаартай албан бичгээр иргэн Г.Баттүшигийн барилгад хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахад нийт эдэлбэр газрын 83 хувьд барилгажихаар төлөвлөгдсөн нь Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь заалтыг зөрчсөн болох нь эрх бүхий байгууллагын хяналт шалгалтаар тогтоогдсон.

Мөн анхан болон давж заалдах шатны шүүхээс Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/646 дугаар захирамжаар 2830 м.кв талбай бүхий газрыг төвлөрсөн авто машины зогсоол, үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмших эрхийг олгосон, гэтэл дээр дурдсан Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт нь нэхэмжлэгчид ийнхүү газар эзэмших эрх үүсэхээс өмнөх хугацаанд хамаарах нөхцөл байдалд хяналт, шалгалт хийсэн байх төдийгүй нэхэмжлэгч нь тус газартаа 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр олон давхар зогсоол бүхий үйлчилгээтэй орон сууцны барилга барих МЗХ2022/15-017 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулж, 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр БАЗГ2023/666 дугаартай Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авч, улмаар барилгын ажил гүйцэтгэж байгаа болох нь ажил гүйцэтгэх гэрээний хуулбарууд, шүүхээс маргаан бүхий газарт хийсэн

211

Үзлэгийн тэмдэглэл зэргээр тогтоогдож байх тул маргаан бүхий актын үндэслэл үгүйсгэгдэж байна гэж дүгэнсэн.

Мөн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн Улсын хяналтын байцаагчийн 2023 оны 031/103 дугаартай албан шаардлагаар иргэн Г.Баттүшигт хүргүүлсэн албан шаардлагыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан готлох баримтаар авч хэлэлцэлзгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн.


Гэтэл Улсын дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай 15 дугаар тогтоолд "Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасан "... хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ..." гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй" гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно" гэж тайлбарлсан бөгөөд Архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ зэргээр тус газрыг бодитоор ашиглаж байгаа гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал үгүйсгэгдэж байна.

Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 128/ШШ2025/0534 дүгээр шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дүгээр сарын 01-ний 221/МА2025/0631 дугаар магадлалыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.5 дахь хэсэгт зааснаар бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү.

ХАРИУЦАГЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ


Г. ЛУВСАНДАНЗАНЖАНЦАН

С.МӨНХДӨЛ

/2025.11.04/

Г.ЛУВСАНДАНЗАНЖАНЦАН